



ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот
2022 он

Хянасан:

Б.Түмэн-Өлзий /Албаны дарга,
мэдээлэл зүйн мэргэжилтэн, докторант/

Тайлан боловсруулсан:

Б.Баянзул /Албаны НЭМ-ийн мэргэжилтэн/

Х.Мөнхзул /Албаны эпидемиологич/

Г.Хулан /Албаны эпидемиологич/

ГАРЧИГ

- Товчилсон үгийн жагсаалт
- Үзүүлэлт тооцох аргачлал

БҮЛЭГ 1

- 2021 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 2

- 2021 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 3

- Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын мэдээ, тайлангийн үнэлгээ
 - Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын бүртгэл, цахим мэдээний сан, сарын мэдээ, жилийн эцсийн тайлантай холбоотой анхаарах зүйлс, нийтлэг гарч буй хүндрэл, алдааны тухай
-

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
СТСА	Статистик тандалт судалгааны алба
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
МЯСЭ	Монгол-Японы сургалтын эмнэлэг
ЦТЭ	Цэргийн төв эмнэлэг
ТЗНЭ	Төмөр замын нэгдсэн эмнэлэг
ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
ХАЯТТ	Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БГДЭМТ	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв
БЗДНЭМТ	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
СХДНЭМТ	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
СБДНЭМТ	Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
ХУДНЭМТ	Хан уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
ЧДНЭМТ	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв
НаДЭМТ	Налайх дүүргийн эрүүл мэндийн төв
БндЭМТ	Багануур дүүргийн эрүүл мэндийн төв
БхдЭМТ	Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв

ҮЗҮҮЛЭЛТ ТООЦСОН АРГАЧЛАЛ

1. Осол гэмтлийн өвчлөлийн тохиолдлын түвшинг (ТТ) тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шинэ тохиолдлын тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
 2. Осол гэмтлийн тархалтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд осол гэмтлийн шалтгаанаар эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
 3. Осол гэмтлийн шалтгаан тус бүрийн өвчлөлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн (ӨОУА-10 дагуу осол гэмтлийн шалтгаан тус бүрээр) осол гэмтлийн шинэ өвчлөлийн тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
 4. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
 5. Осол гэмтлийн үхлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөлийн тоонд харьцуулан, 1 000 гэмтэл тутамд тооцно.
 6. Осол гэмтлийн шалтгаан бүрт нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд тухайн шалтгаанаар бүртгэгдсэн нас баралтыг тухайн жилийн хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.
 7. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын болон өвчлөлийн тархалтыг харуулахдаа тухайн аймаг, дүүрэгт бүртгэгдсэн тохиолдлыг тухайн аймаг дүүргийн хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.
-





I БҮЛЭГ

**2021 оны осол гэмтлийн шалтгаант
өвчлөлийн байдалд хийсэн дүн
шинжилгээ**

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛИЙН БАЙДАЛ 2021 ОН

1. Ерөнхий хэсэг

2021 онд Монгол улсын хэмжээнд 142442 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 2.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн 10000 хүн амд ногдох осол гэмтлийн түвшин 0.7 тохиолдлоор буурсан байна.




2021 онд осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 61% нь эрэгтэй, 39% нь эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна.

2021 онд тохиолдлын түвшин эрэгтэйд 531.5, эмэгтэйд 336.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэйд 5.5 тохиолдлоор буурч, эмэгтэйд 3.2 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна. Осол гэмтлийн өвчлөлд эрчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их өртөж байгаа үзүүлэлттэй байна.


/Жич: 2021 оны хүн амын үзүүлэлт жилийн эцсийн хүн ам биш болно. Тухайн үзүүлэлт 2022 оны 3 сард гарах ба одоогийн үзүүлэлтийг 2021 оны эхний 6 сарын хүн амаар тооцов./

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, хүйсээр, 10 000 хүн амд




Осол гэмтлийн шинэ тохиолдлын тоо насны бүлгээр 0-4 насанд хамгийн өндөр байна.

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, насны бүлгээр





Осол гэмтлийн шинэ тохиолдлын тоо эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсэнд 0-4 насанд (эрэгтэй 12.8%, эмэгтэй 16.3%) хамгийн өндөр байгаа бол 65-69 насанд хамгийн бага бүртгэгдсэн байна.

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, насны бүлэг, хүйсээр



2021 онд бүртгэгдсэн нийт осол гэмтлийн шинэ тохиолдлын 9.8% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 1.9%-иар буурсан үзүүлэлттэй байна. Насны бүлгээр 30-34 насанд бусад наснаас их бүртгэгдсэн байна.



2021 ОНЫ ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДЛЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН:




Түүнчлэн насны бүлгээс хамааран осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан харилцан адилгүй байдаг. 2021 онд бүх насны бүлэгт уналт 1-р шалтгаан болсон байна. Насны бүлэг тус бүрт тэргүүлэх шалтгааныг дараах хүснэгтээс харна уу.

Насны бүлэг	Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
0-4 нас	Уналт 45.6%	Амьд механик хүчинд өртөх 15.6%	Амьгүй механик хүчинд өртөх 13.2%	Түлэгдэлт 14.7%	Тодорхойгүй осол 6.3%
5-9 нас	Уналт 53.7%	Амьгүй механик хүчинд өртөх 15.7%	Амьд механик хүчинд өртөх 12.0%	Зам тээврийн осол 8.9%	Түлэгдэлт 4.3%
10-14 нас	Уналт 52.2%	Зам тээврийн осол 14.5%	Амьгүй механик хүчинд өртөх 14.4%	Амьд механик хүчинд өртөх 9.7%	Хүчирхийлэл 3.5%
15-19 нас	Уналт 40.7%	Амьгүй механик хүчинд өртөх 19.1%	Зам тээврийн осол 15.0%	Хүчирхийлэл 10.6%	Амьд механик хүчинд өртөх 7.6%
20-24 нас	Уналт 32.6%	Амьгүй механик хүчинд өртөх 22.9%	Зам тээврийн осол 14.9%	Хүчирхийлэл 14.7%	Амьд механик хүчинд өртөх 5.6%
25-29 нас	Уналт 31.6%	Амьгүй механик хүчинд өртөх 22.8%	Хүчирхийлэл 16.8%	Зам тээврийн осол 13.0%	Амьд механик хүчинд өртөх 5.6%
30-34 нас	Уналт 33.5%	Амьгүй механик хүчинд өртөх 21.3%	Хүчирхийлэл 16.6%	Зам тээврийн осол 12.6%	Амьд механик хүчинд өртөх 5.2%
35-39 нас	Уналт 33.8%	Амьгүй механик хүчинд өртөх 20.6%	Хүчирхийлэл 16.6%	Зам тээврийн осол 13.3%	Амьд механик хүчинд өртөх 4.4%
40-44 нас	Уналт 36.0%	Амьгүй механик хүчинд өртөх 18.2%	Хүчирхийлэл 15.9%	Зам тээврийн осол 12.9%	Амьд механик хүчинд өртөх 4.6%
45-49 нас	Уналт 38.2%	Амьгүй механик хүчинд өртөх 18.0%	Зам тээврийн осол 13.7%	Хүчирхийлэл 12.3%	Амьд механик хүчинд өртөх 5.3%
50-54 нас	Уналт 44.1%	Амьгүй механик хүчинд өртөх 15.6%	Зам тээврийн осол 12.5%	Хүчирхийлэл 9.6%	Амьд механик хүчинд өртөх 5.3%
55-59 нас	Уналт 49.9%	Амьгүй механик хүчинд өртөх 14.2%	Зам тээврийн осол 11.7%	Хүчирхийлэл 7.1%	Амьд механик хүчинд өртөх 5.2%
60-64 нас	Уналт 54.9%	Амьгүй механик хүчинд өртөх 12.1%	Зам тээврийн осол 10.7%	Амьд механик хүчинд өртөх 5.8%	Хүчирхийлэл 5.9%
65-69 нас	Уналт 61.7%	Амьгүй механик хүчинд өртөх 10.1%	Зам тээврийн осол 8.3%	Амьд механик хүчинд өртөх 5.9%	Тодорхойгүй осол 4.2%
70+ нас	Уналт 72.6%	Амьгүй механик хүчинд өртөх 6.5%	Зам тээврийн осол 5.2%	Амьд механик хүчинд өртөх 4.4%	Тодорхойгүй осол 4.7%
Нийт	Уналт 42.0%	Амьгүй механик хүчинд өртөх 17.5%	Зам тээврийн осол 11.2%	Хүчирхийлэл 9.7%	Амьд механик хүчинд өртөх 7.7%

2021 онд бүртгэгдсэн нийт осол гэмтэлд өртсөн **23.1%** нь толгойн гэмтлийн оноштой байна. Мөн 36.7% нь дээд мөчдийн гэмтэл, 24.4% нь доод мөчдийн гэмтлийн оноштой байна.

Гэмтсэн эрхтний байршил	2021 /хувиар/
Тархины гэмтэл S00-S09	23.1
Хүзүүний гэмтэл S10-S19	0.8
Цээжний гэмтэл S20-S29	5.4
Хэвлийн гэмтэл S30-S39	4.8
Мөр ба бугалганы гэмтэл S40-S49	5.1
Тохой ба шууны гэмтэл S50-S59	14.5
Бугуй ба сарвууны гэмтэл S60-S69	11.7
Түнх ба гуяны гэмтэл S70-S79	3.4
Өвдөг ба шилбэний гэмтэл S80-S89	9.5
Шагай ба тавхайн гэмтэл S90-S99	11.5
Биеийн олон хэсгийн гэмтэл T00-T09	0.6
Бусад болон тодорхойгүй хэсгийн гэмтэл T10-T14	1.5
Түлэгдэлт, осголт, хордох, биеийн сүвээр гадны биет орох г.м T15-T88	8.1
Нийт %	100


Эрэгтэй эмэгтэй аль ч хүйсэнд толгойн гэмтэл, шагай ба тавхайн гэмтэл болон өвдөг шилбэний гэмтэл тэргүүлж байна.




Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан бүрт ямар эрхтэн илүү гэмтсэн байгааг авч үзэхэд зам тээврийн ослын үед гавал доторх гэмтэл, унаж гэмтэх үед зөөлөн эдийн гэмтэл, амьгүй болон амьтай механик хүчинд өртөх, хүчирхийллийн шалтгааны үед шархны онош тэргүүлсэн байна.

Осол гэмтлийн шалтгаан	Гэмтлийн онош				
	I	II	III	IV	V
Зам тээврийн осол (V01-V99)	Гавал доторх гэмтэл 28.0%	Зөөлөн эдийн гэмтэл 27.3%	Хугарал 23.9%	Шарх 9.0%	Бусад болон тодорхойгүй 5.7%
Уналт (W00-W19)	Зөөлөн эдийн гэмтэл 40.9%	Хугарал 29.9%	Мэдрэлийн гэмтэл 10.3	Шарх 9.8%	Гавал доторх гэмтэл 6.9%
Амьгүй механик хүчинд өртөх (W20-W49)	Шарх 53.5%	Зөөлөн эдийн гэмтэл 20.9%	Хугарал 11.0%	Биеийн сүвүүдээр орсон гадны биет 4.8%	Гавал доторх гэмтэл 4.1%
Амьтай механик хүчинд өртөх (W50-W64)	Шарх 41.5%	Мэдрэлийн гэмтэл 23.5	Зөөлөн эдийн гэмтэл 19.3%	Хугарал 11.0%	Гавал доторх гэмтэл 3.0%
Дайралт, халдлага /Хүчирхийлэл/ (X85-Y09)	Шарх 35.6%	Гавал доторх гэмтэл 22.1%	Зөөлөн эдийн гэмтэл 18.7%	Хугарал 17.0%	Бусад болон тодорхойгүй 3.6%


Осол гэмтлийн шинэ тохиолдлын **28.7%** зун, 27.0% намар, 22.3% өвөл, 22.0% хаврын улиралд бүртгэгдсэн байна.



2021 онд осол гэмтлийн шалтгаант өвчлөл 7, 8 саруудад хамгийн их /16.6%/, 2, 4 /12.1%/ саруудад хамгийн бага бүртгэгдсэн байна.




2021 онд бүртгэгдсэн нийт осол гэмтлийн 119882 тохиолдол буюу 84.2% нь нийслэлд 22560 тохиолдол буюу 15.8% нь орон нутагт бүртгэгджээ. Нийслэлийн 10000 хүн тутмын 784.3 нь орон нутгийн 10000 хүн тутмын 127.9 нь осол гэмтэлд өртөж байна. Осол гэмтлийн шинэ тохиолдлын тоо өмнөх оноос нийслэлд 0.2%-иар, орон нутагт 10.9%-иар буурсан байна.



Тухайн газар нутгийн 10000 хүн ам тутамд ногдох тохиолдлын түвшин Дорноговь, Хэнтий, аймгуудад өндөр, Ховд аймагт хамгийн бага байна.


Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, харьяаллаар, 10 000 хүн амд




2021 онд 10 аймагт зам тээврийн ослын шалтгаант өвчлөл, 9 аймагт уналтын шалтгаант өвчлөл тэргүүлсэн бол Говьсүмбэр, Өмнөговь аймгуудад амьгүй механик хүчинд өртөх гэмтэл их байсан байна. Түүнчлэн хүчирхийллийн шалтгаант өвчлөл Ховд аймгаас бусад газарт тэгүүлэх шалтгааны 3-5-р байрт орсон байна.

Аймгийн нэр	Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
Архангай n=1872	ЗТО 30.8%	Уналт 18.4%	Хүчирхийлэл 15.9%	Амьгүй м/х өртөх 15.3%	Амьтай м/х өртөх 7.3%
Баян-Өлгий n=720	Уналт 65.0%	ЗТО 15.1%	Амьгүй м/х өртөх 3.9%	Түлэгдэлт 6.0%	Амьтай м/х өртөх 2.9%
Баянхонгор n=1235	Уналт 38.0%	ЗТО 26.7%	Хүчирхийлэл 9.9%	Амьгүй м/х өртөх 8.3%	Түлэгдэлт 7.0%
Булган n=433	ЗТО 36.0%	Уналт 18.7%	Амьгүй м/х өртөх 17.1%	Хүчирхийлэл 10.2%	Түлэгдэлт 6.0%
Говь-Алтай n=1112	ЗТО 30.7%	Уналт 26.0%	Амьгүй м/х өртөх 15.1%	Хүчирхийлэл 9.6%	Түлэгдэлт 7.2%
Говьсүмбэр n=258	Амьгүй м/х өртөх 25.2%	Уналт 24.0%	ЗТО 17.4%	Хүчирхийлэл 10.1%	Түлэгдэлт 9.3%
Дархан-уул n=1881	Уналт 39.6%	Амьгүй м/х өртөх 20.0%	Хүчирхийлэл 19.6%	ЗТО 9.7%	Түлэгдэлт 5.8%
Дорноговь n=2233	Уналт 29.0%	Амьгүй м/х өртөх 22.1%	ЗТО 18.1%	Хүчирхийлэл 16.7%	Түлэгдэлт 4.9%
Дорнод n=1183	Уналт 34.9%	ЗТО 25.2%	Амьгүй м/х өртөх 15.5%	Хүчирхийлэл 8.3%	Түлэгдэлт 6.9%
Дундговь n=604	ЗТО 36.9%	Уналт 22.5%	Хүчирхийлэл 13.6%	Амьгүй м/х өртөх 8.4%	Түлэгдэлт 7.8%
Завхан n=768	ЗТО 30.5%	Амьгүй м/х өртөх 18.9%	Хүчирхийлэл 16.3%	Уналт 15.1%	Амьтай м/х өртөх 8.1%
Орхон n=872	Уналт 38.2%	ЗТО 23.6%	Амьгүй м/х өртөх 17.3%	Хүчирхийлэл 6.5%	Санамсаргүй хордолт 4.7%
Өвөрхангай n=970	Уналт 30.8%	ЗТО 26.5%	Амьгүй м/х өртөх 15.9%	Хүчирхийлэл 9.8%	Амьтай м/х өртөх 6.7%
Өмнөговь n=1287	Амьгүй м/х өртөх 30.9%	ЗТО 26.2%	Уналт 14.7%	Хүчирхийлэл 11.3%	Түлэгдэлт 7.1%
Сүхбаатар n=577	ЗТО 32.4%	Уналт 21.8%	Амьгүй м/х өртөх 11.1%	Түлэгдэлт 10.1%	Хүчирхийлэл 9.9%
Сэлэнгэ n=979	ЗТО 21.9%	Амьгүй м/х өртөх 20.0%	Уналт 19.7%	Хүчирхийлэл 19.0%	Амьтай м/х өртөх 7.3%
Төв n=1617	Уналт 45.2%	ЗТО 16.0%	Амьгүй м/х өртөх 16.8%	Хүчирхийлэл 8.4%	Амьтай м/х өртөх 4.6%
Увс n=755	ЗТО 30.1%	Амьгүй м/х өртөх 27.8%	Уналт 14.0%	Түлэгдэлт 8.0%	Хүчирхийлэл 6.0%
Ховд n=381	Уналт 43.6%	ЗТО 20.7%	Амьгүй м/х өртөх 10.5%	Түлэгдэлт 10.5%	Амьтай м/х өртөх 5.3%
Хөвсгөл n=1114	ЗТО 26.6%	Амьгүй м/х өртөх 18.6%	Хүчирхийлэл 15.5%	Уналт 15.3%	Түлэгдэлт 7.7%
Хэнтий n=1709	Уналт 39.6%	Амьгүй м/х өртөх 20.0%	Хүчирхийлэл 19.6%	ЗТО 9.6%	Түлэгдэлт 5.8%
Улаанбаатар n=119882	Уналт 44.5%	Амьгүй м/х өртөх 17.5%	Хүчирхийлэл 19.2%	ЗТО 8.8%	Амьтай м/х өртөх 8.2%


Осол гэмтлийн шалтгаант өвчлөл төвийн бүсэд хамгийн өндөр байгаа бол баруун бүсэд хамгийн бага байна.



Осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 44.4% гэртээ, 30.9% гудамж замд гэмтсэн байна.




Нийт тохиолдлын 89.2% нь эрүүл мэндийн байгууллагад өөрөө, 8.8% нь түргэн тусламжаар, 2% нь такси болон бусад аргаар эмнэлэгт ирсэн байна.




1.1. УНАЛТЫН ШАЛТГААНТ ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДОЛ /W00-W19/


2021 онд Улсын хэмжээнд уналтын шалтгаант 59839 шинэ тохиолдол бүртгэгдэж, осол гэмтлийн өвчлөлийг тэргүүлсэн хэвээр байна. Уналтын шалтгаант өвчлөлийн 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 181.8 байгаа ба өмнөх оноос 1.4 тохиолдлоор өссөн байна.



Унаж гэмтсэний улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийн 52.9%-ийг эрэгтэйчүүд, 47.9%-ийг эмэгтэйчүүд эзэлсэн бол тохиолдлын түвшин эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 26.3 тохиолдлоор их байна.




Уналтын шалтгаант өвчлөлийг насны бүлгээр авч үзэхэд тохиолдлын тоогоор 0-4 насны хүүхдэд их буюу нийт тохиолдлын 15.4%-ийг эзэлсэн байна.



Бүх насны бүлэгт нэг түвшин дээр, хальтирч тээглэж бүдэрч ойчих /W01/ төрлийн уналт тэргүүлсэн байгаа бол тоглоомын талбайн хэрэгслээс ойчих гэмтэл 5-14 насанд 2-р шалтгаан болсон байна. Орноос унах гэмтэл 0-9, 60-64, 70+ насанд илүүтэй тохиолддог байна.


Насны бүлэг	Уналтын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр 2020				
	I	II	III	IV	V
0-4	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 46.2%	Орноос ойчих 25.8%	Сандлаас ойчих 5.7%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.6%	Тоглоом ба спортын талбай 3.8%
5-9	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 45.8%	Тоглоом ба спортын талбай 13.8%	Орноос ойчих 9.0%	Тэшүүр, цана, чарганаас ойчих 7.6%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 6.6%
10-14	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 49.7%	Тоглоом ба спортын талбай 14.0%	Тэшүүр, цана, чарганаас ойчих 8.4%	Шат гишгүүрээс ойчих 7.5%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.2%
15-19	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 53.0%	Шат гишгүүрээс ойчих 12.8%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 6.5%	Тоглоом ба спортын талбай 6.4%	Тэшүүр, цана, чарганаас ойчих 5.9%
20-24	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 51.6%	Шат гишгүүрээс ойчих 15.6%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 7.4%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.7%	Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 5.1%
25-29	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 50.1%	Шат гишгүүрээс ойчих 19.0%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 8.6%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 6.5%	Хүнтэй мөргөлдөх, түлхэгдэн ойчих 3.5%
30-34	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 51.7%	Шат гишгүүрээс ойчих 17.9%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 9.2%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.1%	Барилга, байгууламжаас ойчих 3.1%
35-39	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 51.0%	Шат гишгүүрээс ойчих 17.4%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 10.4%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.7%	Барилга, байгууламжаас ойчих 3.3%
40-44	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 50.4%	Шат гишгүүрээс ойчих 18.1%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 11.0%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 8.2%	Барилга, байгууламжаас ойчих 2.9%
45-49	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 52.8%	Шат гишгүүрээс ойчих 16.3%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 11.9%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.4%	Барилга, байгууламжаас ойчих 2.9%
50-54	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 54.4%	Шат гишгүүрээс ойчих 16.3%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 13.9%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 6.2%	Барилга, байгууламжаас ойчих 2.1%
55-59	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 57.7%	Шат гишгүүрээс ойчих 15.6%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 12.8%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.1%	Сандлаас ойчих 3.0%
60-64	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 60.7%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 13.0%	Шат гишгүүрээс ойчих 12.2%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.7%	Орноос ойчих 1.7%
65-69	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 64.6%	Шат гишгүүрээс ойчих 11.6%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 10.8%	Сандлаас ойчих 4.1%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 3.2%
70+	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж бүдэрч унах 69.1%	Шат гишгүүрээс ойчих 9.3%	Нэг түвшин мөс, цасан дээр унах 6.8%	Орноос ойчих 5.9%	Сандлаас ойчих 4.1%

Унаж гэмтсэн хүмүүсийн хамгийн их хувь нь тохой ба шууны /19.3%/, шагай тавхайн /19.2%/, гэмтэл авдаг байна.




Гэмтлийн онош	Тохиолдлын тоо	Хувь
Тохой ба шууны гэмтэл /S50-S59/	11522	19.3
Шагай ба тавхайн гэмтэл /S90-S99/	11485	19.2
Толгойн гэмтэл /S00-S09/	10244	17.1
Өвдөг ба шилбэний гэмтэл /S80-S89/	8078	13.5
Бугуй ба сарвууны гэмтэл /S60-S69/	3701	6.2
Мөр ба бугалгын гэмтэл /S40-S49/	4150	6.9
Хэвлий, зоо нуруу, ууц ба аарцгийн гэмтэл /S30-39/	3642	6.1
Цээжний гэмтэл /S20-S29/	3572	5.9
Түнх ба гуя орчмын гэмтэл /S70-S79/	2352	3.9
Их бие , мөч буюу биеийн бүсийн тодорхойгүй хэсгийн гэмтэл /T10-T14/	662	1.1
Хүзүүний гэмтэл /S10-S19/	317	0.5
Биеийн олон хэсгийг хамарсан гэмтэл /T00-T09/	114	0.2
Нийт	59839	100%


Нийт унаж гэмтсэн тохиолдлын 3.1% нь гэмтэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан ба осол гарах үеийн байршлаар авч үзвэл 47.4% нь гэртээ, 28.7% нь гудамж замд гэмтсэн байна.



Унаж гэмтсэн тохиолдлын 27.2% нь зуны улиралд бүртгэгдсэн байна.




2021 оны уналтын шалтгаант өвчлөлийн 89.1% нийслэлд 01.9% орон нутагт бүртгэгджээ. Нийслэлийн 10000 хүн ам тутам ногдох тохиолдлын түвшин өмнөх оноос 15 тохиолдлоор нэмэгдсэн байгаа бол хөдөө орон нутагт тохиолдлын түвшин өмнөх онтой харьцуулахад ижил буюу 3.7 тохиолдлоор буурсан байна.




1.2. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /V01-V99/


2021 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгааны 3 дугаар байранд зам тээврийн осол орсон байна. Өнгөрсөн онд зам тээврийн осолд өртсөний улмаас 15957 хүн эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авсан нь 10000 хүн ам тутамд 6 тохиолдлоор буурсан байна.




2021 онд зам тээврийн осолд өртсөн иргэдийн 66.8% эрэгтэйчүүд, 33.2% эмэгтэйчүүд байна. Монгол улсын 10000 эрэгтэй тутмын 65.6, 10000 эмэгтэй тутмын 31.8 нь зам тээврийн осолд өртөж байгаа бөгөөд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2 дахин их байна.



Зам тээврийн осолд ямар насны хүмүүс илүү өртөж байгааг авч үзвэл тохиолдлын тоогоор 30-34 насанд хамгийн их байгаа бол тохиолдлын түвшин 20-24 насанд хамгийн өндөр байна.



Зам тээврийн осолд өртөх тохиолдол эрэгтэйд 30-34 насанд, эмэгтэйд 20-24 насанд хамгийн их байна.



2021 онд ачааны машинтай явж байгаад гэмтсэн тохиолдлын 73.7%, суудлын машинтай явж байгаад гэмтсэн тохиолдлын 26.3% нь гэмтэл авах үедээ хамгаалах суудлын бүс хэрэглээгүй байна.



Зам тээврийн осолд өртсөн иргэдийн хамгаалах бүс хэрэглэсэн байдал

Суудлын машинтай зам тээврийн осолд орсон




Ачааны машинтай зам тээврийн осолд орсон



Нийт тохиолдлын **9.9%** нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртсөн байна.

Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх




- Согтууруулах ундаа хэрэглээгүй
- ▨ Согтууруулах ундаа хэрэглэсэн




Жил бүр 1800 гаруй хүн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртөж байна. Өөрөөр хэлбэл 10000 хүн тутмын 4.8-7.2 тохиолдол нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртсөн гэсэн өгүүлэмжтэй байна.


Зам тээврийн шалтгаант өвчлөл, согтууруулах ундаа хэрэглэсэн байдал, 10 000 хүн амд



2021 онд зам тээврийн осол зуны улиралд /38.2%/ даваа гаригт /14.8%/ хамгийн их бүртгэгдсэн байна.




Зам тээврийн осол бүртгэгдсэн, гарагаар



Зам тээврийн осол 6, 7, 8 саруудад буюу зуны улиралд хамгийн их тохиолдож байна.

Зам тээврийн осол бүртгэгдсэн сараар



Зам тээврийн осолд өртөх үедээ аль насны бүлэг ямар тээврийн хэрэгслээр зорчиж байсныг авч үзэхэд 5 хүртэлх болон 24-64 насанд суудлын машинд явж байх үедээ зам тээврийн осолд өртсөн тохиолдол хамгийн их бүртгэгдсэн байгаа бол 5-9 насанд явган явж байх үедээ тээврийн хэрэгсэлд мөргүүлж гэмтсэн тохиолдол 1-р шалтгаан болж байна. Ихэнх насны бүлэгт суудлын машин дотор явж байхдаа гэмтсэн тохиолдол тэргүүлж, ердийн хөсөг буюу морь, тэмээнээс унаж гэмтсэн тохиолдол 10-14 насанд 1-р байрыг эзэлж, бүх насны бүлгийн тэргүүлэх 5 шалгаанд орсон байна.


Насны бүлэг	Тээврийн хэрэгслийн төрөл 2020 он				
	I	II	III	IV	V
0-4	V40-V49 60.4%	V01-V09 25.8%	V20-V39 5.4%	V80-V89 3.2%	V10-V19 2.1%
5-9	V01-V09 26.9%	V40-V49 26.9%	V80-V89 23.5%	V10-V19 14.7%	V20-V39 5.6%
10-14	V80-V89 34.4%	V10-V19 17.3%	V20-V39 16.1%	V10-V19 15.9%	V40-V49 26.9%
15-19	V20-V39 24.4%	V01-V09 21.5%	V40-V49 21.4%	V10-V19 15.5%	V80-V89 14.6%
20-24	V40-V49 42.1%	V01-V09 21.7%	V20-V29 20.2%	V80-V89 7.9%	V10-V19 5.6%
25-29	V40-V49 43.3%	V20-V39 22.7%	V01-V09 16.2%	V80-V89 8.2%	V10-V19 4.9%
30-34	V40-V49 40.8%	V20-V39 23.7%	V01-V09 16.6%	V80-V89 8.8%	V10-V19 5.2%
35-39	V40-V49 39.2%	V20-V39 24.3%	V01-V09 17.1%	V80-V89 9.7%	V50-V69 5.4%
40-44	V40-V49 34.1%	V20-V39 24.6%	V01-V09 21.3%	V80-V89 11.7%	V50-V69 4.4%
45-49	V40-V49 30.9%	V20-V39 27.1%	V01-V09 23.2%	V80-V89 9.1%	V50-V69 5.4%
50-54	V40-V49 29.8%	V20-V39 26.8%	V01-V09 25.0%	V80-V89 11.9%	V50-V69 3.5%
55-59	V40-V49 32.3%	V20-V39 25.4%	V01-V09 23.1%	V80-V89 10.9%	V50-V69 3.2%
60-64	V40-V49 33.1%	V01-V09 27.4%	V20-V39 19.4%	V80-V89 13.7%	V50-V69 3.0%
65-69	V01-V09 29.6%	V40-V49 28.0%	V80-V89 18.8%	V20-V39 18.3%	V50-V69 2.7%
70+	V01-V09 39.9%	V40-V49 36.3%	V80-V89 11.3%	V20-V39 8.9%	V10-V19 3.0%

Тээврийн хэрэгслийн төрлийг гэмтсэн эрхтний байршлаар авч үзвэл дугуйтай зорчигчоос бусад үед тархины гэмтэл тэргүүлж байна. Тээврийн хэрэгслийн төрөл бүрт тэргүүлэх гэмтлийн оношийг дараах хүснэгтээс харна уу.

Тээврийн хэрэгслийн төрөл	Гэмтлийн онош				
	I	II	III	IV	V
V01-V09 (Явган)	Тархины гэмтэл (S00-S09) 34.3%	Өвдөг ба шилбэний гэмтэл (S80-S89) 15.5%	Шагай ба тавхайн гэмтэл (S90-S99) 13.3%	Хэвлийн гэмтэл (S30-S39) 9.7%	Цээжний гэмтэл (S20-S29) 5.7%
V10-V19 (Дугуй)	Тохой ба шууны гэмтэл (S50-S59) 25.2%	Тархины гэмтэл (S00-S09) 21.6%	Өвдөг ба шилбэний гэмтэл (S80-S89) 14.5%	Бугуй ба сарвууны гэмтэл (S60-S69) 8.3%	Мөр ба бугалгын гэмтэл (S40-S49) 7.8%
V20-V39 (Мотоцикл)	Тархины гэмтэл (S00-S09) 38.2%	Өвдөг ба шилбэний гэмтэл (S80-S89) 16.1%	Мөр ба бугалгын гэмтэл (S40-S49) 11.2%	Цээжний гэмтэл (S20-S29) 9.0%	Тохой ба шууны гэмтэл (S50-S59) 5.7%
V40-V49 (Суудлын машин)	Тархины гэмтэл (S00-S09) 56.0%	Цээжний гэмтэл (S20-S29) 10.0%	Хэвлийн гэмтэл (S30-S39) 7.8%	Биеийн олон хэсгийн гэмтэл (T00-T09) 5.1%	Өвдөг ба шилбэний гэмтэл (S80-S89) 3.7%
V50-V69 (Ачааны машин)	Тархины гэмтэл (S00-S09) 41.6%	Цээжний гэмтэл (S20-S29) 14.7%	Хэвлийн гэмтэл (S30-S39) 10.2%	Өвдөг ба шилбэний гэмтэл (S80-S89) 6.5%	Түнх ба гуяны гэмтэл (S70-S79) 5.1%
V70-V49 (Нийтийн тээвэр)	Тархины гэмтэл (S00-S09) 40.3%	Цээжний гэмтэл (S20-S29) 14.5%	Хэвлийн гэмтэл (S30-S39) 11.3%	Өвдөг ба шилбэний гэмтэл (S80-S89) 8.1%	Мөр ба бугалгын гэмтэл (S40-S49) 4.8%
V80-V80.9 (Морь)	Тархины гэмтэл (S00-S09) 25.0%	Мөр ба бугалгын гэмтэл (S40-S49) 16.0%	Тохой ба шууны гэмтэл (S50-S59) 15.8%	Өвдөг ба шилбэний гэмтэл (S80-S89) 11.3%	Цээжний гэмтэл (S20-S29) 9.9%


Зам тээврийн ослын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан /2021/

Зам тээврийн ослын улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн **66.5%** нийслэлд, **33.5%** орон нутагт бүртгэгдсэн байна.





Өнгөрсөн онд зам тээврийн ослын шалтгаант өвчлөл Архангай аймагт хамгийн их бүртгэгдсэн ба тухайн газар нутгийн 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшин мөн адил Архангай, Говь-Алтай, Дорноговь аймагуудад өндөр байна. Харин зам тээврийн ослын тоо болон тохиолдлын түвшин 2020 онд Дархан-Уул аймагт хамгийн бага байсан бол 2021 онд Ховд аймагт бага бүртгэгдлээ.

**Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл, 10 000 хүн амд,
харьяаллаар**




1.3. АМЬГҮЙ МЕХАНИК ХҮЧИНД ӨРТӨЖ ГЭМТЭЛ /W20-W49/

Амьгүй механик хүчинд өртөж гэмтэх шалтгаанаар 2021 онд 24963 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх оноос 3.3%-иар буурсан бөгөөд 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 75.8 байна.




2021 онд амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдлын 71% нь эрэгтэй, 29% эмэгтэйчүүд эзэлж байна.

Амьгүй механик хүчинд өртөж шалтгаант өвчлөлийг насны бүлгээр авч үзэхэд 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшингээр 20-24 нас /118.3/ хамгийн өндөр байна.



2021 онд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдол 3%-ийг эзэлсэн ба хүйсийн байдлаар авч үзэхэд 10 хүн тутмын 8 нь эрэгтэйчүүд байна.




Сүүлийн жилд амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг судлан авч үзэхэд 3 хүн тутмын 1 нь бусад зүйл мөргөх буюу цохигдож гэмтсэн байна.



Амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдлыг насны бүлгээр судлан үзэхэд бүх насанд бусад зүйл мөргөх буюу цохигдох шалтгаан тэргүүлж байгаа бол 2,3-р шалтгаан насны бүлгээс хамааран харилцан адилгүй байна.

Насны бүлэг	АМЬГҮЙ МЕХАНИК ХҮЧИНД ӨРТӨХ ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН				
	I	II	III	IV	V
0-4	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 48.7%	Хоёр юмны хооронд хавчигдах 14.8%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 8.2%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 7.7%	Хурц шилэнд зүсэгдэх 7.3%
5-9	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 44.1%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 12.6%	Хоёр юмны хооронд хавчигдах 11.2%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.5%	Хурц шилэнд зүсэгдэх 8.3%
10-14	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 38.7%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 9.9%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 9.3%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 9.2%	Хурц шилэнд зүсэгдэх 7.4%
15-19	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 34.2%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 12.3%	Хурц шилэнд зүсэгдэх 11.3%	Хутганд өртөх 9%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 8.5%
20-24	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 27.7%	Хурц шилэнд зүсэгдэх 14.3%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 12.0%	Хутганд өртөх 10.5%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 9.6%
25-29	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 27.3%	Хурц шилэнд зүсэгдэх 12.9%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 11.6%	Хутганд өртөх 10.5%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 9.3%
30-34	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 25.7%	Хурц шилэнд зүсэгдэх 12.9%	Хутганд өртөх 11.8%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 10.6%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 9.9%
35-39	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 26.2%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 12.1%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 11.3%	Хурц шилэнд зүсэгдэх 10.4%	Хутганд өртөх 9.9%
40-44	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 24.6%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 13.0%	Хутганд өртөх 11.5%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 10.8%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 8.8%
45-49	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 23.8%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 15.4%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 10.3%	Хутганд өртөх 10.2%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 9.1%
50-54	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 24.6%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 17.0%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 9.6%	Хоёр юмны хооронд хавчигдах 9.0%	Хутганд өртөх 8.9%
55-59	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 25.1%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 19.2%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 10.9%	Нүд ба биеийн сүвүүдээр гадны биет орох 9.5%	Хурц шилэнд зүсэгдэх 7.6%
60-64	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 20.0%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 20.0%	Хутганд өртөх 10.6%	Нүд ба биеийн сүвүүдээр гадны биет орох 10.0%	Хоёр юмны хооронд хавчигдах 9.6%
65-69	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 30.1%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 19.2%	Хутганд өртөх 8.8%	Нүд ба биеийн сүвүүдээр гадны биет орох 8.4%	Хоёр юмны хооронд хавчигдах 8.0%
70+	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 33.8%	Гэр ахуйн хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх 12.4%	Шидэгдсэн, нурсан зүйлд цохиулах 9.5%	Өргөх ба дамжуулах төхөөрөмжтэй хүрэлцэж гэмтэх 9.0%	Нүд ба биеийн сүвүүдээр гадны биет орох 8.6%


2021 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөлийг улирлаар авч үзэхэд зуны улиралд /31%/ хамгийн өндөр байгаа бол өвлийн улиралд /19%/ хамгийн бага тохиолдсон байна.



Амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдлыг харьяаллаар авч үзэхэд 84% нь нийслэлд, 16% нь орон нутагт бүртгэгдсэн байна.



Амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдлын түвшин 10000 хүн амд Дорноговь аймагт /68.8/ хамгийн өндөр байсан бол Баян-Өлгий аймагт /2.6/ хамгийн бага бүртгэгдсэн байна.



Амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдлыг гэмтлийн байршлаар авч үзэхэд 40.1% нь бугуй ба сарвуу хэсгийг гэмтээсэн байна.

№	Гэмтлийн байршил	Бодит тоо	Хувь
1	Бугуй ба сарвууны гэмтэл	10,020	40.1
2	Тархины гэмтэл	4,647	18.6
3	Шагай ба тавхайн гэмтэл	2,598	10.4
4	Тохой ба шуун гэмтэл	2,441	9.8
5	Өвдөг ба шилбэний гэмтэл	1,459	5.8

Осол гэмтэл болсон газрын байршлыг авч үзэхэд амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн 2 тохиолдол тутмын 1 нь гэртээ байхдаа амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн байна.



Дээрхи байршлуудад амьгүй механик хүчинд өртөх осол гэмтэл тохиолдсон тэргүүлэх шалтгааныг судлахад бусад зүйл мөргөх, цохигдох шалтгаан тэргүүлж байна.






II БҮЛЭГ

2021 оны осол гэмтлийн шалгаант нас баралтын байдалд хийсэн дүн шинжилгээ


МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН БАЙДАЛ 2021 ОН

2. Ерөнхий хэсэг

2021 онд гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 3026 тохиолдол бүртгэгдсэн нь нийт шинэ тохиолдлын 2.1%-ийг эзэлж байна. 2020 онд осол гэмтлийн шалтгаант нас баралт өмнөх оноос 3.2%-иар буурсан хэдий ч 2021 онд өмнөх онтой харьцуулахад 10.6 хувиар эрс өссөн үзүүлэлттэй байна. Мөн 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 2020 онд өмнөх оноос 0.5 тохиолдлоор буурч, 2021 онд 2.5 тохиолдлоор өссөн байгаа нь анхаарал татахуйц байна.



2021 оны осол гэмтлийн шалтгаант нас баралт, хүйсээр



Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 79.2% нь эрэгтэйчүүд, 20.8% нь эмэгтэйчүүд байна.


82%

Эрэгтэй



2021 онд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтэл хордлого, гадны шалтгаант осолд өртөж нас барсан 1619 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд түүний 82.0% эрэгтэй, 18.0% эмэгтэй хүмүүс байжээ.


Тухайн онд бүртгэгдсэн нас баралтын түвшин өмнөх оноос 10 000 эрэгтэйд 1 тохиолдлоор буурсан бол 10 000 эмэгтэйд 0.2 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.



2021 онд гэмтэл хордлого, гадны шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын дундаж нас 40.3, хамгийн багадаа дөнгөж төрсөн нярай гэмтэж нас барсан байгаа бол хамгийн ахмад нь 93 настай байна.

Age median	Std.Dev	min	max
40.3	16.4	0	93

Гэмтэл хордлого гадны шалтгаант нас баралтыг насны бүлгээр 10 000 хүн амд графикаар авч үзвэл 2021 онд тохиолдлын тоогоор 40-44 насанд, нас баралтын түвшинээр 50-54 насанд хамгийн их тохиолдол бүртгэгдсэн байна.



2021 онд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтыг насны бүлгээр өмнөх онтой харьцуулан судлахад 0-4, 70-с дээш насныханд тохиолдлын тоо болон 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин буурсан байгаа хэдий ч бусад бүх насны бүлэгт нас баралтын түвшин өссөн үзүүлэлттэй байна. 2020, 2021 онуудад 40-44 насныхан бодит тоогоор тэргүүлж байсан бол 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 50-54 насныханд өндөр хэвээр байна.

Насны бүлэг	2020 он		2021 он	
	Бодит тоо	Нас баралтын түвшин	Бодит тоо	Нас баралтын түвшин
0-4	150	3.9	110	3.0
5-9	53	1.4	55	1.4
10-14	63	2.1	69	2.2
15-19	90	4.1	98	4.5
20-24	117	4.9	165	7.3
25-29	194	7.3	184	7.6
30-34	264	8.5	319	10.9
35-39	301	11.6	357	14.1
40-44	328	14.4	384	17.5
45-49	325	16.0	375	19.0
50-54	309	18.0	346	20.5
55-59	253	17.6	265	18.3
60-64	136	12.8	145	13.5
65-69	63	10.8	75	12.1
70+	90	10.5	79	9.1

2021 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын 77.1% нь санамсаргүй үйлдэгдсэн осол гэмтэл /Үүнд дотроо 43.6% нь хордолт/ эзэлж байгаа бол 22.9% нь өөрийнхөө болон бусдын амь насанд санаатайгаар халдсан тохиолдлууд эзэлж байна.


САНААТАЙ ОСОЛ ГЭМТЭЛ

/Амиа хорлолт болон хүчирхийллийн шалтгаант осол гэмтэл/



САНАМСАРГҮЙ ОСОЛ ГЭМТЭЛ

/Уналт, зам тээврийн осол, амьгүй болон амьтай механик хүчинд өртөх, усанд живэлт, түлэгдэлт, хордолт гэх мэт/




Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 1-рт санамсаргүй хордох, хорт бодист өртөх **33.6%** /1018/, 2-рт амиа хорлолт **15.9%** /482/, 3-рт зам тээврийн осол **15.5%** /468/, 4-рт хүчирхийлэл **6.9%** /210/, 5-рт уналт **6.8%** /206/ тус тус тэргүүлж байна.

ГЭМТЭЛ, ХОРДЛОГО ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН:




Тухайн тайлангийн жилд бүртгэгдсэн 1000 шинэ гэмтэл тутамд ногдох үхлийн түвшинээр усанд живж нас барах, амьсгал боогдох, санамсаргүй хордох, байгалийн хүчинд өртөх, амиа хорлох зэрэг шалтгаанууд /302.4-857.1 тохиолдол/ тэргүүлж байна. Энэ нь усанд живсэн 1000 шинэ гэмтэл тутамд 857.1 тохиолдол нь нас баралтаар төгсөж байгааг харуулж байна.





Осол гэмтлийн шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгаан нь насны бүлэг бүрт харилцан адилгүй байна. 2021 онд 0-4 насанд амьсгал боогдох шалтгаант осол, 5-14 насанд зам тээврийн осол, 15-29 насанд амиа хорлолт, 30-69 насанд санамсаргүй хордох, хорт бодист өртөх, 70+ насанд уналтын шалтгаант нас баралт тэргүүлж байна.

Насны бүлэг	Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан-2021 он				
	I	II	III	IV	V
0-4нас /n=110/	Амьсгал боогдох 29.1%	Зам тээврийн осол 22.7%	Усанд живэх 20.0%	Түлэгдэлт 7.3%	Хордох 6.4%
5-9нас /n=55/	Зам тээврийн осол 34.5%	Хордох 16.4%	Усанд живэх 10.9%	Түлэгдэлт 10.9%	Уналт 7.3%
10-14нас /n=69/	Зам тээврийн осол 33.3%	Амиа хорлох 24.6%	Усанд живэх 14.5%	Уналт 8.7%	Хордох 4.3%
15-19нас /n=98/	Амиа хорлох 43.9%	Зам тээврийн осол 17.3%	Уналт 12.2%	Усанд живэх 12.2%	Хордох 6.1%
20-24нас /n=165/	Амиа хорлох 35.8%	Зам тээврийн осол 18.8%	Хордох 12.7%	Уналт 12.1%	Байгалийн хүчинд өртөх 6.1%
25-29нас /n=184/	Амиа хорлох 31.5%	Зам тээврийн осол 21.7%	Хордох 16.3%	Уналт 9.8%	Хүчирхийлэл 6.5%
30-34нас /n=319/	Хордох 24.6%	Амиа хорлох 22.9%	Зам тээврийн осол 16.6%	Хүчирхийлэл 8.1%	Усанд живэх 6.0%
35-39нас /n=357/	Хордох 35.8%	Амиа хорлох 21.0%	Зам тээврийн осол 12.9%	Хүчирхийлэл 7.8%	Байгалийн хүчинд өртөх 7.3%
40-44нас /n=384/	Хордох 44.0%	Зам тээврийн осол 16.1%	Амиа хорлох 10.9%	Хүчирхийлэл 8.3%	Байгалийн хүчинд өртөх 6.2%
45-49нас /n=375/	Хордох 40.5%	Зам тээврийн осол 14.4%	Амиа хорлох 13.1%	Хүчирхийлэл 9.1%	Байгалийн хүчинд өртөх 6.7%
50-54нас /n=346/	Хордох 46.2%	Зам тээврийн осол 12.1%	Байгалийн хүчинд өртөх 10.1%	Амиа хорлох 9.5%	Хүчирхийлэл 7.5%
55-59нас /n=265/	Хордох 52.4%	Зам тээврийн осол 10.2%	Байгалийн хүчинд өртөх 10.2%	Уналт 6.4%	Хүчирхийлэл 5.7%
60-64нас /n=145/	Хордох 35.9%	Зам тээврийн осол 12.4%	Байгалийн хүчинд өртөх 12.4%	Хүчирхийлэл 10.3%	Уналт 7.6%
65-69нас /n=75/	Хордох 41.3%	Уналт 9.3%	Байгалийн хүчинд өртөх 9.3%	Хүчирхийлэл 9.3%	Тодорхойгүй осол 9.3%
70+нас /n=79/	Уналт 29.1%	Хордох 20.2%	Байгалийн хүчинд өртөх 11.4%	Тодорхойгүй осол 10.1%	Зам тээврийн осол 8.9%

2021 онд бүртгэгдсэн нийт гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 29.9% нь намрын улиралд бүртгэгдсэн байна.




Нийт гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт 10, 11 дүгээр сард хамгийн өндөр бүртгэгдсэн байна.




2021 онд бүртгэгдсэн гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт даваа гаригт 15.8% /479/ хамгийн өндөр бүртгэгдсэн байна.

2021 онд бүртгэгдсэн нийт осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 1839 нь нийслэлд, 1187 нь орон нутагт бүртгэгдсэн ба 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин нийслэлд 12.0, орон нутагт 6.7 байна.



Орон нутагт осол гэмтлийн шалтгаант нас баралтын 1187 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс тохиолдлын тоогоор Хөвсгөл аймагт хамгийн их тохиолдол бүртгэгдсэн бол тухайн газар нутгийн 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин Говьсүмбэр аймагт /10.5/ хамгийн өндөр, Дархан-Уул аймагт /2.4/ хамгийн бага үзүүлэлттэй байна.



Аймаг тус бүрт тэргүүлж буй осол гэмтлийн шалтгаант нас баралтыг дараах хүснэгтээс харна уу.

Харъяалал	Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
Архангай /n=95/	Зам тээврийн осол 26.3%	Амиа хорлох 20.0%	Байгалийн хүчинд өртөх 18.9%	Усанд живэх 14.7%	Амьсгал боогдох 7.4%
Баян-Өлгий /n=53/	Зам тээврийн осол 43.4%	Усанд живэх 18.9%	Амиа хорлох 15.1%	Уналт 7.5%	Түлэгдэлт 3.8%
Баянхонгор /n=51/	Зам тээврийн осол 29.4%	Амиа хорлох 29.4%	Хордох 11.8%	Усанд живэх 7.8%	Хүчирхийлэл 5.9%
Булган /n=41/	Зам тээврийн осол 29.3%	Амиа хорлох 29.3%	Амьсгал боогдох 9.8%	Хордох 9.8%	Хүчирхийлэл 7.3%
Говь-Алтай /n=54/	Амиа хорлох 27.8%	Зам тээврийн осол 18.5%	Байгалийн хүчинд өртөх 18.5%	Амьсгал боогдох 13.0%	Уналт 7.4%
Говьсүмбэр /n=19/	Зам тээврийн осол 21.0%	Амиа хорлох 21.0%	Хордох 21.0%	Түлэгдэлт 10.5%	Хүчирхийлэл 10.5%
Дархан-Уул /n=25/	Хордох 36.0%	Уналт 24.0%	Амиа хорлох 16.0%	Зам тээврийн осол 12.0%	Амьсгал боогдох 8.0%
Дорнод /n=52/	Зам тээврийн осол 40.4%	Хордох 15.4%	Амиа хорлох 13.5%	Байгалийн хүчинд өртөх 9.6%	Усанд живэх 5.8%
Дорноговь /n=54/	Хордох 33.3%	Зам тээврийн осол 22.2%	Амиа хорлох 14.8%	Хүчирхийлэл 9.3%	Байгалийн хүчинд өртөх 7.4%
Дундговь /n=36/	Байгалийн хүчинд өртөх 30.6%	Зам тээврийн осол 19.4%	Амиа хорлох 16.7%	Усанд живэх 11.1%	Хордох 8.3%
Завхан /n=34/	Зам тээврийн осол 32.3%	Амиа хорлох 17.6%	Уналт 8.8%	Хордох 8.8%	Усанд живэх 8.8%
Орхон /n=95/	Хордох 43.2%	Амиа хорлох 12.6%	Уналт 11.6%	Зам тээврийн осол 10.5%	Хүчирхийлэл 5.3%
Өвөрхангай /n=67/	Зам тээврийн осол 34.3%	Амиа хорлох 19.4%	Хордох 17.9%	Усанд живэх 6.0%	Уналт 6.0%
Өмнөговь /n=51/	Зам тээврийн осол 31.4%	Хордох 21.6%	Амиа хорлох 19.6%	Амьсгал боогдох 7.8%	Байгалийн хүчинд өртөх 7.8%
Сүхбаатар /n=39/	Зам тээврийн осол 38.5%	Байгалийн хүчинд өртөх 15.4%	Хордох 12.8%	Амиа хорлох 10.3%	Хүчирхийлэл 10.3%
Сэлэнгэ /n=74/	Амиа хорлох 28.4%	Зам тээврийн осол 17.6%	Хордох 14.9%	Усанд живэх 13.5%	Амьсгал боогдох 9.5%
Төв /n=76/	Зам тээврийн осол 30.3%	Хордох 30.3%	Амиа хорлох 11.8%	Усанд живэх 6.6%	Байгалийн хүчинд өртөх 5.3%
Увс /n=65/	Зам тээврийн осол 33.8%	Амиа хорлох 33.8%	Байгалийн хүчинд өртөх 10.8%	Хордох 10.8%	Усанд живэх 6.1%
Ховд /n=40/	Зам тээврийн осол 45.0%	Амиа хорлох 20.0%	Усанд живэх 12.5%	Байгалийн хүчинд өртөх 7.5%	Хордох 5.0%
Хэнтий /n=59/	Зам тээврийн осол 33.9%	Амиа хорлох 32.2%	Байгалийн хүчинд өртөх 8.5%	Уналт 8.5%	Амьгүй механик хүчинд өртөх 6.8%
Хөвсгөл /n=107/	Амиа хорлох 25.2%	Хордох 20.6%	Усанд живэх 18.7%	Зам тээврийн осол 16.8%	Хүчирхийлэл 4.7%
Улаанбаатар /n=1839/	Хордох 43.8%	Амиа хорлох 12.7%	Хүчирхийлэл 8.8%	Уналт 8.5%	Зам тээврийн осол 8.0%

Осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшин орон нутгийн хувьд 10 000 хүн амд Хангайн бүсэд хамгийн өндөр бүртгэгдсэн байна.





Монгол улсад 2020 онд осол гэмтлийн 1000 шинэ тохиолдол тутмын 10.1 нь нийслэлд, 46.7 нь орон нутагт бүртгэгдэж байсан бол 2021 оны байдлаар нийслэлд 5.2, орон нутагт 5.9 тохиолдлоор өссөн байна. Мөн 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин нийслэлд 2.3 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн харьяаллаар	2020 он		2021 он	
	Нас баралтын түвшин	Үхлийн түвшин /1000 хүн амд/	Нас баралтын түвшин	Үхлийн түвшин /1000 хүн амд/
Улаанбаатар	9.7	10.1	12.0	15.3
Орон нутаг	6.7	46.7	6.7	52.6

2.1. САНАМСАРГҮЙ ХОРДОХ, ХОРТ БОДИСТ ӨРТӨХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /Х40-Х49/

2021 онд улсын хэмжээнд санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралт 1018 тохиолдол бүртгэгдэж нас баралтын тэргүүлэх шалтгаан болсоор байна. 2021 оны хувьд осол гэмтлийн шинэ тохиолдол өмнөх оноос тодорхой хувиар буурсан хэдий ч хордож нас барсан тохиолдол өмнөх онтой харьцуулахад 31.5%-иар өссөн үзүүлэлттэй байгаа нь анхаарал татахуйц байна. Мөн 10000 хүн ам тутмын 3.1 тохиолдол нь нас баралтаар төгссөн байна.




Хордож нас барсан тохиолдлын 78%-ийг эрэгтэйчүүд, 21%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд 10 хүн тутмын 8 нь санамсаргүй байдлаар хордож нас барсан байна.

Монгол улсад 2021 оны байдлаар гэмтэл, хордлого гадны шалтгаант нийт нас баралтын 33.6%-ийг санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаан тэргүүлж байна.








Санамсаргүй хордох, хорт бодист өртөж нас барах тохиолдол 45-49 насанд тохиолдлын тоогоор хамгийн их байгаа бол 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 55-59 насанд өндөр байна. Харин бусад насны бүлэгт санамсаргүй хордох, хорт бодист өртсөн тохиолдол харилцан адилгүй бүртгэгдсэн байна.




Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын **99.6%** нь эмийн бус бодист хордсон байна.




Санамсаргүй хордох, хорт бодист өртөж нас барсан тохиолдлын тэргүүлэх шалтгааныг авч үзвэл **спиртэнд санамсаргүй хордсон тохиолдол дангаараа 84.2%**-ийг эзэлж байна.

-  **X45** Спиртэнд санамсаргүй хордох 84.2%
-  **X47** Бусад хий, ууранд санамсаргүй хордох, өртөх 14.5%
-  **X49** Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох, өртөх 0.7%
-  **X44** Бусад ба тодорхойгүй эм, эмийн бэлдмэл, биологийн бодист санамсаргүй хордох, өртөх 0.4%
-  **X48** Хортон шавьж устгах хоронд санамсаргүй хордох өртөх 0.1%


Санамсаргүй хордож нас барсан нийт тохиолдол намрын улиралд 31.5%-ийг эзэлж байна. Хүйсийн хувьд авч үзэхэд эрэгтэйчүүд намрын улиралд, эмэгтэйчүүд зуны улиралд хамгийн их нас барсан байна.



2021 онд санамсаргүй хордож нас барсан тохиолдлыг сараар авч үзвэл бодит тоо болон хувиар 10, 11 сард хамгийн их тохиолдол бүртгэгдсэн байна.




2021 онд хордож нас барсан тохиолдлын 79.1% нь нийслэл хотод, 20.9% нь хөдөө орон нутагт бүртгэгдлээ.




Жилд нийслэлийн 10000 хүн ам тутмын 3-4 хүн, хөдөө орон нутгийн 10000 хүн ам тутмын 1 нь санамсаргүй хордож, хорт бодисд өртөж нас барж байна. Нийслэлд 2020 онд нийслэлд өмнөх оноос нас баралтын түвшин өссөн байгаа бол орон нутагт буурсан үзүүлэлттэй байна.

Хордож нас барсан тохиолдол, харьяаллаар





Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралтын 84.2%-ийг /Х45/ спиртэнд хордох шалтгаан эзэлдэг ба 2021 оны байдлаар Монгол улс сард дунджаар 71, өдөрт дунджаар 1-2 хүнээ хордлогын улмаас алдсан байна.




2.2. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /V01-V99//

2021 онд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 468 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин өмнөх оноос 0.1 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.




Зам тээврийн ослоор амь насаа алдсан нийт тохиолдлын 79.3% нь эрэгтэйчүүд, 20.7% нь эмэгтэйчүүд байна.


Зам тээврийн ослоор нас барсан тохиолдлын тоо болон нас баралтын түвшин 40-44 насанд хамгийн өндөр байна.




Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртөж нас барсан тохиолдлын тоо болон өсөлтийн хувь өмнөх онуудаас буурсан боловч 2021 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 31.8% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ нас барсан байна.



2021 оны зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 33.7% нь намар, 28.0% нь зун, 21.4% нь өвөл бүртгэгдсэн бол хаврын улиралд хамгийн бага /16.9%/ бүртгэгджээ.




Сараар авч үзвэл 2020 онд 7 сард хамгийн их тохиолдол бүртгэгдэж байсан бол 2021 онд 10 сард хамгийн их хувь нь нас барсан байна.



2021 оны байдлаар суудлын машинтай зорчих үедээ зам тээврийн осолд өртсөн тохиолдол 35.3%, явган зорчигч тээврийн хэрэгсэлд мөргүүлж нас барсан тохиолдол 26.9%, мотоциклын ослоор амь насаа алдсан тохиолдол 23.7%-ийг тус тус эзэлжээ.

**Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын
тэргүүлэх 5 шалтгаан /2021/**



Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын дийлэнх тохиолдол нь буюу 68.6% орон нутагт бүртгэгджээ.




Зам тээврийн ослын шалтгаант нас баралтыг тархины гэмтлийн улмаас нас барсан тохиолдол тэргүүлж байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, гэмтлийн байршлаар




Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын тохиолдлын тоо болон нас баралтын түвшин Архангай аймагт хамгийн их бүртгэгдсэн бол тухайн газар нутгийн 10000 хүн амд ногдох нас баралтын түвшин Увс аймагт мөн өндөр байгаа бол Дархан-Уул аймагт хамгийн бага байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, харьяаллаар




2.3. АМИА ХОРЛОХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /Х60-Х84/

Монгол улсад 2021 онд амиа хорлож нас барсан 482 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 6.9%-иар өссөн үзүүлэлттэй байна. Тухайн онд санаатайгаар өөртөө гэмтэл учруулах шалтгаант нас баралтын түвшин 10000 хүн ам тутамд 1.4 байна.




Сүүлийн 3 жилийн байдлаар санаатайгаар өөртөө гэмтэл учруулсан нас баралтын түвшин 10 000 хүн амд 1.4 байгаа бол үхлийн түвшин 1000 гэмтэл тутамд 9.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.





Хүйсийн байдлаар авч үзвэл амиа хорлож нас барсан нийт тохиолдлын 85% нь эрэгтэй, 15% нь эмэгтэй байна.

2021 онд амиа хорлож нас барсан тохиолдлыг насны бүлгээр авч үзвэл эрэгтэй хүйсэнд 35-39 насанд /65/ хамгийн их, эмэгтэй хүйсэнд 30-34 насанд /12/ хамгийн их тохиолдол бүртгэгдсэн байна.




Нас баралтын түвшинг судлахад 30-39 насанд /1.9/ хамгийн өндөр, 5-9 насанд /0.1/ хамгийн бага байна.



Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан тохиолдлыг согтууруулах ундаа хэрэглэсэн байдлаар судлан үзэхэд 63% нь согтууруулах ундаа хэрэглээгүй байна.


**АМИА ХОРЛОЖ НАС БАРСАН ТОХИОЛДЛЫН
ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН**




Амиа хорлож нас барсан тохиолдлын тэргүүлэх шалтгааныг насны бүлэг бүрт тооцоход аль ч насанд өөрийгөө дүүжлэх, боймлох шалтгаан тэргүүлж байна.

Насны бүлэг	Тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
5-9 n=3	Өөрийгөө дүүжлэх, боох 100%				
10-14 n=17	Өөрийгөө дүүжлэх, боох 88.2%	Өндрөөс үсрэх 12.7%			
15-19 n=43	Өөрийгөө дүүжлэх, боох 86%	Өндрөөс үсрэх 4.6%	Өөрийгөө буугаар буудах 2.3%	Усанд живэх 2.3%	Гал, дөл, ууранд түлэх 2.3%
20-24 n=59	Өөрийгөө дүүжлэх, боох 88.2%	Өөрийгөө буугаар буудах 6.7%	Спирт, бусад бодисд хордох 1.7%	Иртэй зүйлээр өөрийгөө гэмтээх 1.7%	Өндрөөс үсрэх 1.7%
25-29 n=58	Өөрийгөө дүүжлэх, боох 89.6%	Өөрийгөө буугаар буудах 6.8%	Гал, дөл, ууранд түлэх 3.6%		
30-34 n=73	Өөрийгөө дүүжлэх, боох 91.7%	Иртэй зүйлээр өөрийгөө гэмтээх 5.5%	Өөрийгөө буугаар буудах 1.4%	Гал, дөл, ууранд түлэх 1.4%	
35-39 n=75	Өөрийгөө дүүжлэх, боох 89.3%	Иртэй зүйлээр өөрийгөө гэмтээх 6.6%	Өөрийгөө буугаар буудах 4.2%		
40-44 n=42	Өөрийгөө дүүжлэх, боох 90.4%	Өөрийгөө буугаар буудах 4.8%	Иртэй зүйлээр өөрийгөө гэмтээх 2.4%	Спирт, бусад бодисд хордох 2.4%	
45-49 n=49	Өөрийгөө дүүжлэх, боох 95.9%	Өндрөөс үсрэх 4.1%			
50-54 n=33	Өөрийгөө дүүжлэх, боох 94%	Гал, дөл, ууранд түлэх 3%	Иртэй зүйлээр өөрийгөө гэмтээх 3%		
55-59 n=12	Өөрийгөө дүүжлэх, боох 91.6%	Иртэй зүйлээр өөрийгөө гэмтээх 8.4%			
60-64 n=10	Өөрийгөө дүүжлэх, боох 90%	Өндрөөс үсрэх 10%			
65-69 n=5	Өөрийгөө дүүжлэх, боох 100%				
70+ n=3	Өөрийгөө дүүжлэх, боох 100%				

2021 онд амиа хорлож нас барсан нийт тохиолдлыг улирлаар авч үзэхэд намар болон зуны улиралд хамгийн өндөр байсан бол өвөл /119/, хавар /112/ хамгийн бага бүртгэгдсэн байна.




Санаатайгаар өөртөө гэмтэл учруулан нас барсан тохиолдлыг бүртгэгдсэн сараар авч үзэхэд 2020 оны 5 дугаар сард их тохиолдол бүртгэгдэж байсан бол энэ онд 5 болон 12 дугаар сард бусад саруудаас илүү амиа хорлож нас барсан тохиолдол бүртгэгдсэн байна.




Амиа хорлох үедээ хэрэглэсэн арга, хэрэгсэл



Амиа хорлоход хүргэсэн хэлбэр




**Амиа хорлож нас барсан тохиолдол,
харьяаллаар**



2021 оны байдлаар амиа хорлож нас барсан тохиолдлыг харьяаллаар авч үзэхэд 52% нь орон нутагт, 48% нь нийслэлд бүртгэгдсэн байна.

Амиа хорлож нас барсан тохиолдлыг бүртгэгдсэн аймгаар судлан үзэхэд Говь-Алтай, Увс аймагт 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшингээр тэргүүлж байгаа бол Дархан-Уул, Сүхбаатар аймагт хамгийн бага байна.

Амиа хорлож нас барсан тохиолдол, 10 000 хүн амд





III БҮЛЭГ

**Харилцагч эрүүл мэндийн
байгууллагуудын тандалтын
мэдээ, тайлангийн үнэлгээ**

**Осол гэмтлийн шалтгаант өвчлөл,
нас баралтын бүртгэл, цахим
мэдээний сан, сарын мэдээ,
жилийн эцсийн тайлантай
холбоотой анхаарах зүйлс,
нийтлэг гарч буй хүндрэл,
алдааны тухай**

3.1. Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын 2020 оны Осол гэмтлийн тандалтын тайлан хамгаалсан үнэлгээ

Үнэлгээний тайлбар:

2021 оны “Осол гэмтэл, гадны шалтгааны үр дагавар”-ын тайланг хүлээн авахдаа харилцагч эрүүл мэндийн байгууллагуудыг 6 үзүүлэлтээр үнэлсэн. Үүнд:

1. Цахим тайлангийн үнэлгээг Hinfo V3.0 программаас бодуулсан ЭМТ-310.1, ЭМТ-310.2, ЭМТ-310.3 тайлангуудыг сарын мэдээтэй тулган үнэлсэн.
2. Нас баралтын мэдээ болон бааз гэсэн үнэлгээг сар бүр мэдээллэж байсан гадны шалтгаант нас баралт нь Hinfo V3.0 программын AM-7 -оос экспортолсон бааз болон ЭМХТөвийн мэдээтэй таарч буй байдлаар үнэлсэн.
3. Стационарын баазад өгсөн үнэлгээг өөрийн эмнэлэгт осол гэмтлийн шалтгаанаар хэвтэн эмчлүүлсэн өвчтөний мэдээллийг цахимаар илгээсэн байдлаар үнэлсэн.
4. Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдлыг сар бүрийн 5-ны дотор мэдээлсэн бүх сарыг 12-т хуваан 100-аар үржүүлэн үнэлсэн.
5. Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироог үнэлэхдээ ЭМХТөв, НЭМГазарт мэдээллэж байсан осол гэмтлийн мэдээ нь тандалтын мэдээтэй таарч буй эсэхээр үнэлсэн.
6. Мэдээний сангийн алдааг “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас” маягтын асуумж бүрээр үнэлсэн.

Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн үнэлгээний хуудас

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Үнэлгээний төрөл							Дүн %/
		ЭМТ 310.1 ЭМТ 310.2 ЭМТ 502 маягуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй таарсан	Тайлан зааврын дагуу үнэн, зөв бодуулсан байдал	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	
		26 оноо	10 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	12 оноо	20 оноо	
1	УНТЭ	26	10	10	10	12	12	17	97%
2	УХТЭ	26	10	10	10	12	10	16	94%
3	УГТЭ	26	10	10	10	12	12	18	98%
4	ЭХЭМҮТ	26	10	10	10	11.5	11	18	96.5%
5	ГССҮТ	26	10	10	10	12	12	18	98%
6	СЭМҮТ	26	10	10	10	12	12	18	98%
7	ШШҮТ	26	10	9	10	11	12	17	95%

Орон нутгийн ЭМГазруудын үнэлгээний хуудас

№	Аймгийн нэр	Үнэлгээний төрөл							Дүн /%/
		ЭМТ 313.1 ЭМТ 313.2 ЭМТ 502 маягуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй	Тайлангийн зааврын дагуу үнэн, зөв бодуулсан байдал	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	
		26 оноо	10 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	12 оноо	20 оноо	
1	Архангай	26	10	10	10	12	12	17	97%
2	Баян-Өлгий	26	10	10	10	12	11.5	18.5	98%
3	Баянхонгор	26	10	10	10	12	12	17	97%
4	Булган	26	10	10	10	11	12	18	97%
5	Говь-Алтай	26	10	9.5	10	12	12	16	95.5%
6	Говьсүмбэр	26	10	10	10	8	11.5	16.5	92%
7	Дархан-Уул	26	10	9	10	10.5	10.5	18	94%
8	Дорноговь	26	10	10	10	11	12	18	97%
9	Дорнод	26	10	10	10	12	12	17	97%
10	Дундговь	26	10	10	10	12	12	17	97%
11	Завхан	26	10	9	10	12	12	16	95%
12	Орхон	26	10	10	10	10	12	18	96%
13	Өвөрхангай	26	10	10	10	11	12	18	97%
14	Өмнөговь	26	10	9.5	10	12	12	18.5	98%
15	Сүхбаатар	26	10	9	10	12	12	15	94%
16	Сэлэнгэ	26	10	10	10	11	11	18	96%
17	Төв	26	10	9	10	8	10	17	90%
18	Увс	26	10	10	10	12	12	18	98%
19	Ховд	26	10	9	10	6	12	18	91%
20	Хөвсгөл	26	10	8	10	11	12	16	93%
21	Хэнтий	26	10	10	10	12	12	15	95%

НЭМГазрын харъяа эмнэлгүүдийн үнэлгээний хуудас

№	Аймгийн нэр	Үнэлгээний төрөл							
		ЭМТ 310.1 ЭМТ 310.2 ЭМТ 502 маягуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй	Тайлангийн зааврын дагуу үнэн, зөв бодуулсан байдал	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	Дүн /%/
		26 оноо	10 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	12 оноо	20 оноо	100 оноо
1	Хүүхдийн төв сувилал	26	10	10	10	12	12	18	98%
2	Наркологи	26	10	10	10	12	12	18	98%
3	ЦТЭ	26	10	10	10	12	10	17	96%
4	ТЗНЭ	26	10	10	10	6	12	18	92%
5	ТТАХНЭ	26	10	10	9	12	10	18	95%
6	МВГ	26	10	10	10	12	-	20	88%
7	БГДЭМТ	26	10	10	10	10	12	18	96%
8	БЗЭмнэлэг ХХК	26	10	10	10	11	10	17	95%
9	БЗДЭМТ	26	10	9	10	12	10	16	93%
10	СХДЭМТ	26	10	10	10	11.5	10	18	95.5%
11	СБДНЭ	26	10	10	10	7	12	18	93%
12	СБДЭМТ	26	10	10	10	12	11	18	97%
13	ХУДЭМТ	26	10	10	10 -	12	12	18	98%
14	ЧДЭМТ	26	10	10	9	12	9	18	94%
15	Налайх	26	10	8	10	12	10	17	93%
16	Багануур	26	10	10	10	12	12	15	95%
17	Багахангай	26	10	10	10	9.5	12	16.5	94%
18	Жаргалант	26	10	10	10	12	12	18	98%
19	Гачуурт	26	10	10	10	10	12	18	96%
20	Хонхор	26	10	10	10	12	12	16	96%
21	Туул	26	10	9	10	10.5	12	17	94.5%
22	Мөнгөнгүүр	26	10	10	9	10	10	15	90%
23	Интермед	26	10	9	10	12	12	18	97%
24	Энэрэл	26	10	10	10	12	12	18	98%

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын мэдээний санд сар бүр гарч буй нийтлэг алдааны тухай

ГССҮТөвийн СТСАлбаны мэргэжилтнүүд эмнэлгүүдийн осол гэмтлийн өвчлөл, нас баралтын сарын мэдээг цахимаар хүлээн авч Hinfo V3.0 программ дахь бүртгэлтэй тулган, бүртгэлийн болон логик алдаа байгаа тохиолдолд тухай бүрт нь хариу илгээдэг тул очсон и-мэйл-н дагуу мэдээний сангийн алдаагаа сар бүрдээ хянаж хэвшинэ үү!

/Тайлангийн үеэр эмнэлэг бүрт биечлэн дэлгэрэнгүй тайлбарлаж зааж өгсөн ба дараах зүйлсийг анхан шатанд үзлэг хийн маягт хөтөлж буй эмч нартаа анхааруулна уу/

1. Регистрийн дугаар буруу орсон тохиолдолд нас, хүйс буруу бүртгэгдэх тохиолдол байна. Жишээ нь: 100-аас дээш настай хүмүүсийн ихэнх нь регистрийн дугаар буруу оруулсантай холбоотойгоор нас нь 100-р нэмэгдсэн буюу хүүхдүүд байх нь элбэг байдаг. Тиймээс 100-аас дээш настай хүмүүсийн бүртгэлээ үнэн эсэхийг нягталж хэвшинэ үү
 2. 15 хүртэлх насны хүүхдүүд дунд, дээд боловсролтой болон аль нэг газар ажил эрхэлдэг гэсэн сонголт хийгдсэн байгаа эсэхийг шалгаж хэвших. Учир нь 5 настай хүүхдэд дээд боловсролтой, мөн 8 настай хүүхдэд ажил эрхэлдэг гэх мэт логикийн хувьд алдаатай бүртгэлүүд элбэг тохиолддог. Энэ нь хувь хүний мэдээллийн хэсгийг сайн шалгаагүйтэй холбоотой. Түүнчлэн хүүхэд байх үед нь бүртгэсэн мэдээллээ шинэчилдэггүйтэй холбоотойгоор насанд хүрсэн хүмүүсийн албан тушаал 0-15 насны хүүхэд гэж бүртгэгдэж байна.
 3. Согтууруулах ундаа хэрэглэсэн гэж мэдээлсэн тохиолдлууд дунд насанд хүрээгүй хүүхэд байгаа тохиолдолд үнэн эсэхийг заавал нягталсны дараа бүртгэх, мэдээлэх
 4. Мансууруулах бодис хэрэглэсэн гэж сонгогдсон тохиолдолд заавал эргэн шалгах, лавлах
 5. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын тоо нь тухайн гэмтсэн хүний ямар тээврийн хэрэгслээр явж байсныг зааж байгаа бөгөөд энэ нь арагш задарсан асуултын 1-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь:
V тэмдэглэгээний ард 1 гэсэн болон эхний асуултад унадаг дугуйг сонгоно гэсэн үг юм. Явган зорчигч бол V үсэгний ард 0 байна гэх мэт.
 6. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын 2-р тоо нь тухайн гэмтсэн хүн ямар тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөнийг зааж байгаа ба энэ нь арагш задарсан асуултын 3-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь:
Суудлын машинтай явж байсан хүн шон мөргөөд түүнээсээ болж гэмтсэн бол 3 дахь асуултанд хөдөлгөөнгүй зүйл мөргөсөн гэдгийг сонгох ба V47-р кодолно.
 7. Морь болон тэмээнээс унаж гэмтсэн тохиолдлыг ердийн хөсөгнөөс унасан буюу V80-р кодлох ба 2-р эгнээний асуултанд хариулахдаа жолооч, зорчигч гэх мэт сонголт огт хийхгүй. Зөвхөн уралдааны морь унаач эсвэл энгийн морь унаач гэсэн сонголтыг хийнэ.
 8. Хүчирхийлэл буюу өвчний олон улсын ангиллаар Дайралт, халдлага X85-Y09-өөр кодлогддог шалтгаанд биеийн болон бэлгийн бүх төрлийн санаатайгаар нэгнээ гэмтээсэн тохиолдлууд орохыг анхаарна уу. Өөрөөр хэлбэл биеэрээ болон мод, чулуу, шил, хутга гэх мэт зэвсэг ашиглан зодолдсон тохиолдлууд орно. Зарим тохиолдолд бусдад зодуулсан хүмүүсийн гэмтлийн шалтгааныг W50-аар буруу кодолсон байна. Өвчний олон улсын ангиллаар W50 нь бусад хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, мушгиулах, хазуулах, маажуулах тохиолдлууд орох ба энэ нь зөвхөн санамсаргүй гэмтээсэн тохиолдолд л сонгогдох код гэдгийг анхаарна уу. Жишээ нь:
Тоглож байгаад санаандгүй нэгнээ түлхэж унагаад гэмтээсэн, сагс тоглож байгаад санаандгүй маажуулсан, гараа эргүүлж байсан хүнд санаандгүй цохигдох зэрэг нь W50
-

ангилалд орно. Харин санаатайгаар цохисон, маажсан, өшиглөсөн бол хүчирхийлэл гэсэн ангилалд оруулна. Мөн яг юу ашиглан зодсоныг нь тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлт тайлбар бичнэ үү!

9. Түүнчлэн хүчирхийллийг кодлохдоо хэрэглэсэн арга зүйлээс нь хамаарч ялгаатай кодолдог болохыг анхаарна уу. Жишээ нь:
Санаатайгаар боосон бол Х91-р, хутгалсан бол Х99-р, мод чулуугаар цохисон бол У00-р, гар хөлөөрөө цохиж зодсон бол У04-р кодлоно.
10. Түлэнхийн шалгаанаар /W85-X19/ тусламж асан хүмүүст Т20-Т32-н хооронд онош тавих ёстой. Бүртгэгдсэн түлэнхийн тохиолдлууд дунд S-тэй оношууд байгааг анхаарна уу. Түүнчлэн яг юунд хэрхэн түлэгдсэн тухай “тусгай тэмдэглэл” багананд дэлгэрүүлэн бичнэ үү! Жишээ нь: халуун тогоотой зүйлд түлэгдсэн тохиолдлыг заавал тодруулан бичнэ үү
11. “Тусгай тэмдэглэл” хэсэгт нэмэлт тайлбар шаардлагатай тохиолдлуудыг тэмдэглэх ба тухайн мөчид юу болсоныг тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлтээр бичнэ. Ингэснээр кодолж чадахгүй байгаа болон эргэлзээтэй тохиолдлуудаа тухай бүрт нь шийдвэрлэх ач холбогдолтой.

НИЙТИЙГ ХАМАРСАН ОСОЛ ГЭМТЭЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН АЛБАНД ЯАРАЛТАЙ МЭДЭЭЛЖ БАЙХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА.

Жишээ нь: Гэр бүлээрээ болон олноороо явж байгаад зам тээврийн осолд орох, ажлын байр, гэр, байшин шатаж олон хүн түлэгдэх, байгалийн гамшиг тохиолдох, барилга байшин үйлдвэр уурхай нурах гэх мэтээс болж 4 болон түүнээс олон хүн 1 дор гэмтсэн, нас барсан тохиолдлуудыг сарын мэдээний хугацааг хүлээлгүйгээр тухай бүрт gemteltandalt@gmail.com хаягаар болон 80081049, 86620105 дугаарт мэдээлнэ үү!

Та бүхний мэдээлж буй “Осол гэмтлийн тохиолдол” бүрийн үнэн, зөв байдал нь цаашид осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нотолгоонд суурилсан үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллийн нэгж болдогийг онцгой анхааран эмч мэргэжилтнүүдээ зөвлөмж арга зүйгээр ханган ажиллана уу!
